

“Далгай эвэрт”

1. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг олоорой.

- A. Ямааны тухай
- B. Малч хүүгийн тухай
- C. Хорвоогийн жам ёсны тухай
- D. Малаа хайрлах ухааны тухай
- E. Малчдын тухай

2. Эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.

- A. Би Далгай эвэртээ бодсоор өрөвдсөөр, хаана үхчихээ бол гэж сэтгэлдээ хонины бэлчээрийн бөөрөг толгодыг нэгжсээр орондоо орлоо.
- B. Энэ Далгай эвэртийг би хэдэн жил мотоцикл болгон унаж тоглосон болохоор их хайрлана.
- C. Амьтан хайрлах гэдэг чухамдаа нинжин сэтгэлийн үүдийг нээдэг ид шидийн түлхүүр мэт бодогдоно.
- D. Жил ирэх тутам Далгай эвэрт өтөлж бид хоёр бие биенээсээ холдсоор...
- E. Амралтын хэд хоног их л уйтгартай өнгөрч, хонь хотлох бүр Далгай эвэртээ үгүйлэн үгүйлнэ.

3. “Ямаа их ямбатай амьтан” гэдгийг батлах баримт аль нь ?

- A. Хонь дагуулан гүйнэ.
- B. Өглөө эрт бэлчинэ.
- C. Яргуй цэцгийн сор хөөнө.
- D. Салхидах дуртайг нь яана.
- E. Сахлыг нь сүлжиж маажин суухад их дуртай сан

4. Өгүүлэгчийн ямаагаа дурсан санаж буйг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.

- A. Өвлийн амралтаар ирчхээд хонь хотлохыг яаран яаран хүлээнэ.
- B. Энэ үед Далгай эвэрт хааяа, хонь орой гэрийн гадуур ирчихсэн байхад над дээр гүйж ирээд эрхлэх гэнэ.
- C. Хот руугаа ортол Далгай эвэрт маань алга. Би хэсэг хайснаа бүүр айж гэртээ орон аав ээж хоёроос Далгай эвэрт хаачсан бэ? гэтэл алга болчихсон гэж аав хэллээ.
- D. Амралтын хэд хоног их л уйтгартай өнгөрч, хонь хотлох бүр Далгай эвэртээ үгүйлэн үгүйлнэ.
- E. Нэг өдөр илүү гэртээ орчихсон бараа уудлан, хуйлаастай сонин онгичин суутал Далгай эвэртийн маань толгой гараад ирэх нь тэр.

5. Өгүүлэгчийн ямаагаа хайрлаж буйг санааг аль хэсэгт түлхүү тусгасан бэ ?

- A. Одоо ч гэсэн Далгай эвэртээ унаад давхихаар санагдана. Гэсэн ч ээж саяхан ишиглэсэн юм, битгий ноолоорой ядарчихна гэсэн болохоор би нэг л зүрхлэхгүй.
- B. Энэ Далгай эвэртийг би хэдэн жил мотоцикл болгон унаж тоглосон болохоор их хайрлана.
- C. Би ээжийг хараад саяхан л хэдэн ямаагаа муулаад байсан. Хар цоохрыгоо ээжээс нь урьтаж тавиад өгчих юмсан гэж бодоод явна.
- D. Энэ үед Далгай эвэрт хааяа хонь орой гэрийн гадуур ирчихсэн байхад над дээр гүйж ирээд эрхлэх гэнэ.
- E. Жил ирэх тусам би том болж Далгай эвэрт өтөлж бид хоёр нэг нэгнээсээ холдсоор...